

“ОЛЛОО” ХК-ий ХЭХ-ын протокол

2023.05.31

Хувьцаа эзэмшигчидийн хойшлогдсон хурал 2023.05.31-ны өдрийн 15.00 цагт компаний байранд хуралдав.

Бүүвэйбаатар: За сайн байцгаана уу. 2023 оны 05 сарын 31-ны өдрийн “Оллоо” ХК-ий ХЭХурал эхэлж байна. Хурлын дэгийг танилцуула. Хурлын ирц бүртгэнэ, хурлын ирцийг мэдээлнэ. Хэлэлцэх асуудлууд нь 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, ТУЗ-ийн дүгнэлт, 2023 оны ажлын төлөвлөгөө, ТУЗ-ийн гишүүдийг томилох, Оллоо ХК-ийн тамга шинэчлэх гэсэн асуудлуудыг хэлэлцэнэ. 4 асуудлыг хэлэлцэнэ тус бүрдээ санал шүүмжлэл хэлнэ, хувьцаа эзэмшигчид үг хэлж санал гаргана, тогтоолын төслийг танилцуулна гэсэн дарааллаар хуралдана. Хурлын ирцийг мэдээлэхэд нийт 2 817 238 ш хувьцаа эзэмшигч буюу 29,04% ирцтэй байна. Хойшлогдсон хурлын ирц хуулийн дагуу бүрдсэн, хүчин төгөлдөр тул хойшлогдсон хурлаа эхэлье. За юуны өмнө Оллоогийн хувьцааг олон жил эзэмшиж, хурлыг хүндэтгэн оролцож, компанийхаа үйл ажиллагаанд санаа тавьж байгаа та бүхэндээ хувийнхаа зүгээс болон компанийхаа зүгээс баярласнаа илэрхийлье. Шууд 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа ярь, хурлын материалыг урьдчилаад хувьцаа эзэмшигчдэд тараасан тул та бүхэн танилцсан байх гэж бодож байна. 2021-2022 он бол маш хүнд өнгөрсөн, короногийн үр нөлөө арилаагүй, Монгол улсын эдийн засгийн байдал айл өрх, албан байгууллага, төр засаг бүгд зардалаа хасаж байна үүнтэй холбогдоод хамгийн түрүүнд маркетингийн зардалаа танасан, гэрээт байгууллагууд маш цөөхөн болсон, тул та бүхэн ойлгоорой. За мөн компанийг удирдаж авч явах тал дээр удирдлагын багийн бид хангалттай ажиллаж чадаагүйгээ хүлээн зөвшөөрч байна. 2022 онд гэрээ хийсэн газрууд гэвэл Голомт, Тавантолгой түлш, Эрдэнэс тавантолгой, ХААН банк, Төрийн банк, зэрэг цөөн хэдэн газрууд гэрээ хийсэн байгаа, уг нь бол олон газар гэрээ хийдэг байсан бол ийм цөөхөн болжээ. Үүнээс үүдээд орлого багассан, цалингаа хангалттай тавьж чадахгүй, интернетийн мөнгөө л төлдөг, түрээсийн зардал гэж байхгүй байгаа.

2023 оны тухайд гэвэл мэдээний бичлэгийн чанарыг сайжруулж, сайтын хандалтыг нэмэгдүүлэх нь энэ жилийн хамгийн чухал ажил зорилт байх болно. Гадаад хэлний орчуулгын чанарт анхааран өөр хэвлэл мэдээлэлд орчуулагдахгүй шинэ содон мэдээг орчуулж уншигчдад хүргэнэ. Оллоо фэйсбүүк хуудсыг идэвхтэй хөгжүүлж, мэдээ мэдээллийг түргэн шуурхай нийтлэх зорилготой LIVE хийх иж бүрэн төхөөрөмж авч өдөр бүр нэг мэдээг онцлон мэдээллэнэ.

За дараагийн хэлэлцэх асуудал бол 2023 оны ажлын төлөвлөгөө. Энэ асуудлыг гүйцэтгэх захирал солигдож байгаа тул ажлын төлөвлөгөө гаргах 1 сарын хугацаа өгч байна. Ажлын төлөвлөгөө гаргангуут ТУЗ-аараа хэлэлцэнэ.

Гуравдугаар асуудал нь ТУЗ-ын гишүүдийг солих тухай юм байна. Энэ асуудал дээр би хуучин гишүүдийг хэвээр үлдээх саналтай байна.

Дөрөвдүгээр асуудал нь Компанийн тамга солих юм байна. Энэ тамга хуучирч, ашиглах боломжгүй болсон тул шинэчилэх нь зөв гэж үзэж байна.

Ц. Энхцэцэг хурлаас гарсан саналуудыг дэмжиж байна.

П.Бүүвэйбаатар: Энэхүү хуралыг ингээд дуусгая баярлалаа.

Хурлын дарга



П.Бүүвэйбаатар